



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 онь 04 сарын 03 өдөр

Дугаар А/182

Хэрлэн сум


Эрдэнэцогтын Оюунчимэгт
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.7 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрдэнэцогтын Оюунчимэгээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Хэнтий аймгийн Баян-Овоо сумын харьяат "Алтан гадас одонт" биеийн тамирын тэргүүний ажилтан, Ардын боловсролын тэргүүний ажилтан, бөхийн чөлөөт барилдааны Спортын мастер, аймгийн Хурц арслан Батмөнхийн Эрдэнэцогт агсны нэрэмжит үндэсний бөхийн өсвөр үе, идэрчүүдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд 1,000,000 (нэг сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (А.Жаргалсайхан)-д захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ

